


2015 ОНЫ ХӨРСНИЙ ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын Багануур, Хан-Уул, Налайх, Баянзүрх дүүргийн нийт 53 цэгээс, орон нутгийн Булган, Говь-Алтай, Хөвсгөл, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь аймгийн нийт 72 цэгээс хөрсний дээж авч хөрсөн дэх хүнд металл кадмий, хартугалга, мөнгөн ус, бром, хром, цайр, зэс, кобальт, стронций, рубиди, циркон, хлорын агууламжийг рентгенфлуоресценци спектрофотометрийн аргаар тодорхойлсон.

Улаанбаатар хотын хөрсний чанар:

Баянзүрх, Хан-Уул, Багануур, Налайх дүүргийн хөрсөнд 2015 онд хийсэн шинжилгээний дүнг 2013 оны дүн, Хөрсний чанар MNS5850:2008 стандарттай харьцуулан доорх зургаар харуулав.


Багануур дүүрэг



Зураг 1. Багануур дүүргийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, мг/кг

Багануур дүүргийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 9 цэгээс дээж авч, шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламж хэвийн, стандартаас давсан бохирдол илрээгүй, харин цэг тус бүрээр авч үзэхэд “Шүүхийн шийдвэр” орчимд цайрын агууламж 1,4 дахин их, бусад бохирдуулах бодис хэвийн байна.


Хан-Уул дүүрэг



Зураг 2. Хан-Уул дүүргийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, 2013, 2015 оноор, мг/кг

Хан-Уул дүүргийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 19 цэгээс хөрсний дээж авч, шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламж хэвийн, харин цэг тус бүрээр нь авч үзэхэд “Харгиа” цэвэрлэх байгууламжийн орчимд хромын агууламж стандартаас 4,4 дахин их, 2013 оны шинжилгээний дүнтэй харьцуулбал 1,6 дахин буурсан, цайрын агууламж “Хүүшийн зоорь” орчимд 1,4 мг/кг-аар их, бусад бохирдуулах бодис хэвийн байна.


Налайх дүүрэг



Зураг 3. Налайх дүүргийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, мг/кг

Налайх дүүргийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 4 цэгээс дээж авч, шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламж хэвийн, харин цэг тус бүрээр нь авч үзэхэд “Голомт цогцолбор сургууль” орчимд стронцийн агууламж 1,2 дахин их, бусад бохирдуулах бодис хэвийн байлаа.

Баянзүрх дүүрэг




Зураг 4. Баянзүрх дүүргийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, мг/кг

Баянзүрх дүүргийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 21 цэгээс хөрсний дээж авч, шинжилгээний дүнгээр “Төмөр замын засварын газар”, “2-р бааз”, “Да хүрээ зах” орчимд цайрын агууламж 1,3-1,8 дахин их, 2013 оны шинжилгээний дүнтэй харьцуулбал дундаж агууламж нь буурсан, стронцийн агууламж Жуковын музей орчимд 1,2 дахин их, бусад бохирдуулах бодис хэвийн байна.

Орон нутгийн хөрсний чанар:

Булган, Говь-Алтай, Өмнөговь, Хөвсгөл, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Дорноговь аймгуудын хөрснөөс дээж авсан. 2015 оны дүнг 2012, 2014 оны дүн болон Хөрсний чанар MNS5850:2008 стандарттай харьцуулан доорх зургаар харуулав.


Булган аймаг:



Зураг 5. Булган аймгийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, мг/кг

Булган аймгийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 5 цэгээс дээж авч шинжилгээ хийсэн. Хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн, харин цэг тус бүрээр нь авч үзэхэд “2-р 10 жилийн уурын зуух” орчмын хөрсөнд мөнгөн ус 4.9 мг/кг буюу 2.5 дахин их, стронцийн агууламж “Колонко”-оос бусад 4 цэг дээр цэг дээр 964,8-1088,4 мг/кг буюу 1,2-1,4 дахин их, бусад бохирдуулах бодис хэвийн байна.


Говь-Алтай аймаг



Зураг 6. Говь-Алтай аймгийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, мг/кг

Говь-Алтай аймгийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 4 цэгээс дээж авч шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн, харин цэг тус бүрээр нь авч үзэхэд “Шинэ-Алтай” зах, “Эрчим хүчний хашаа” орчимд хромын агууламж 1.1-1.2 дахин их, бусад бохирдуулах бодис хэвийн байна.


Өмнөговь аймаг



Зураг 7. Өмнөговь аймгийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, мг/кг

Өмнөговь аймгийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 5 цэгээс дээж авч, шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн, харин цэг тус бүрээр нь авч үзэхэд “Мэргэжил сургалт үйлдвэр”-ийн төвийн орчимд кобальтын агууламж 2,3 дахин их, бусад бохирдуулах бодис хэвийн байсан байна.

Хөвсгөл аймаг



Зураг 8. Хөвсгөл аймгийн хөрсөнд агуулагдах хүнд металлын дундаж агууламж, мг/кг

Хөвсгөл аймгийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 5 цэгээс дээж авч, шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн, харин цэг тус бүрээр нь авч үзэхэд “3-р хорооны ногоон цэцэрлэг” орчимд цайрын агууламж 2,0 дахин, стронцийн агууламж “1-р хорооны халуун ус”, “16-р байр”, “Цэвэрлэх байгууламж”-ийн орчимд тус бүр 1,1 дахин их, бусад бохирдуулах бодис хэвийн байна.

Говьсүмбэр аймаг

Говьсүмбэр аймгийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 5 цэгээс дээж авч, шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн байна.

Дорноговь аймаг

Дорноговь аймгийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 12 цэгээс дээж авч, шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн байна.

Дорнод аймаг

Дорнод аймгийн хөрсний чанарыг тодорхойлохын тулд 12 цэгээс дээж авч шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн, цэг тус бүрээр нь авч үзэхэд мөнгөн усны агууламж “Соёл хүмүүжлийн төв” орчимд 0.1 мг/кг-аар, “Нефть бааз”-аас 600м зайд 0.3 мг/кг-аар их, бусад бохирдуулах бодис хэвийн байна.

Дундговь аймаг

Дундговь аймгийн төвд 10 цэгт хийсэн шинжилгээний дүнгээр хөрсөн дэх бохирдуулах бодисын дундаж агууламжийг Хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад хэвийн байна.

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС